Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Үндэсний цөөнх, хилийн чанад дахь монгол хүүхдийн хэл, соёлын асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Лханаг Батсүрэн

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. ҮНДЭСНИЙ ЦӨӨНХ, ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛ ХҮҮХДЭД ҮНДЭСНИЙ ХЭЛ, ХОС ХЭЛ, ЁС ЗАНШИЛ, БИЧИГ ҮСГИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 1 | Монгол хэл бичгийн сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр Монгол-Тува хэлний мэргэжлийн болон Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх | Хамрагдсан багшийн тоо | 497 (бага боловсрол), 54 (КХУЗ), 124 (АХИС) | 200 | 1. Боловсролын сайдын 2024 оны А/230 дугаар тушаалын дагуу Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн удирдах ажилтнуудад зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах удирдамж боловсруулан БЕГ-ын даргаар батлуулж 2025 оны 01-р сарын 08-наас 01 сарын 24-ний өдрүүдэд аймгийн БГ-ын мэргэжилтнүүд, ЕБС-ийн удирдах ажилтнуудад зохион байгуулсан. Зөвлөн туслах баг аймгийн 12 сумын 15 сургуульд 3 чиглэлийн дагуу зөвлөн тусалж, нэгдсэн сургалт, | 5-р сар, 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уулзалтад нийт 160 удирдах ажилтан хамрагдсан.<br><br>2. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг Баян-Өлгий аймагт зохион байгуулж, хөндлөнгийн хянагчаар 2025 оны 04-р сарын 29-ний өдрөөс 05 -р сарын 02-ны өдрүүдэд Өлгий сумын 15 цэцэрлэгийн (57,6%) үйл ажиллагаанд хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Аймгийн хэмжээнд төрийн өмчийн 56 цэцэрлэгийн 391 үндсэн бүлгийн багшаас 387 хамрагдсан ба үүнээс 43 хөгжмийн багш, 31 биеийн тамирын багш байна.<br><br>3. “Монгол хэл, бичиг- бидний бахархал” өдөрлөг 2025.01.25-ны өдөр БНСУ-ын Сөүл хотын захиргааны хурлын танхимд зохион байгуулагдаж “Монгол, Солонгос хэл бичиг, соёлын төв"-ийн сурагч, эцэг эхчүүд болон сонирхогч 50 хүн хамрагдаж, “Монгол хэл, бичиг” монгол бичгийн уралдааныг 2025.01.15-02.15 хооронд зохион байгуулж сурагчдын ангилалд 12, насанд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрэгчдийн ангилалд 16, нийт 28 бүтээл ирүүлж оролцов.<br>4. “Монгол хэл, бичиг-бидний бахархал” таниулах сургалтыг 2025.01.18-нд Тайваны Тайбэй хот дахь Монгол Төвөдийн соёлын төвийн хичээлийн танхимд зохион байгуулж 12 оролцогч хамрагдаж, “Монгол хэл, бичиг” уралдааныг 2025.01.15-02.15-ны хооронд зохион байгуулж сурагчдын ангилалд 6 хүүхэд, насанд хүрэгчдийн ангилалд 7, нийт 13 бүтээлээ ирүүлж оролцсон.<br>5. “Монгол хэл, бичиг-бидний бахархал” өдөрлөгийг 2025.02.23-ны өдөр Токио хотод Миний Монгол сургуулийн Нихонбаши салбар хичээлийн танхимд зохион байгуулж 50 оролцогч, “Монгол хэл, бичиг” монгол бичгийн уралдааныг 2025.01.15-2025.02.15 хооронд зохион байгуулж ний 40 бүтээл ирүүлж оролцсон.<br>Хавсралт: 12 файл | | |
| 1.2. ҮНДЭСНИЙ ЦӨӨНХ, ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛ ХҮҮХДИЙН СУРГАЛТЫН АГУУЛГА, ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 2 | Хөтөлбөрийн | Гүйцэтгэлийн хувь | Дасгал ажлын | 50 | СӨБ болон бага | 5-р сар, 6-р | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэлийн дагуу шинээр хэвлэгдэх казах, тува хэлний I-V ангийн сурах бичгийн захиалгыг авах, холбогдох газарт хүргүүлэх. | | дэвтэр 8000ш, Толь бичиг 8000ш | | боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдсан Казах хэл IV, V ангийн хоёрдугаар улирлын туршилтын 430 ширхэг сурах бичиг, дасгалын дэвтрийг БСҮХ-ээс хүлээн авч, Баян-Өлгий аймагт хүргүүлсэн. Хөтөлбөрийн шинэчлэлийн дагуу шинээр боловсруулагдаж хэвлэгдэх шаардлагатай сурах бичгийн судалгааг гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Хөтөлбөр шинэчлэн боловсруулах ажил БСҮХ-ээс эцэслэгдээгүй байгаа учир бусад эх хэлэнд хөрвүүлэх, хэвлэх тооцоо судалгаа хүлээгдэж байна. Хавсралт: 1 файл | сар, 8-р сар, 9-р сар | |
| 3 | Монгол хэл, соёлын төвийн багш нарт, зориулсан “Монгол хэл, бичиг” заах арга зүйн цахим цуврал сургалт зохион байгуулах | -Зохион байгуулсан сургалтын тоо, -Хамрагдсан багшийн тоо | - | 9 (сургалт), 100 (багш) | Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд эх хэл,бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын үнэт зүйлийг таниулахад чиглэсэн хилийн чанад дахь Монгол хэл, соёлын төвийн багш нарт "Монгол хэл, бичиг заах" 10 удаагийн цахим сургалтыг 2025.02.02-04.27-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад 278 | 2-р сар, 3-р сар, 4-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багш, удирдлага хамрагдсан.<br>Үүнд:<br>"Монгол хэл, бичиг" илтгэл, хэлэлцүүлэг 2025.01.17-нд "Монгол хэл бичиг, соёлын үнэт өв", "Монгол хэл бичгийн түүхэн сурвалж, дурсгал", "Монгол хэл бичиг ба технологи хэрэглээ" сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.<br>Хэлэлцүүлэгт БЕГ, МУИС-ийн болон хэл соёлын төвийн төлөөлөл 51 хүн оролцсон. "Эх хэлний хичээлд AI болон шинэлэг технологийг ашиглах боломжууд", "сургалтын материал боловсруулахад хэрхэн ашиглах","монгол хэлний зөв дуудлага, ярианы дадлага хийхэд хэрхэн үр дүнтэй ашиглах нь" сургалтыг 2025.02.02-нд зохион байгуулж 37 багш, Хиймэл оюун ухаан PopAi, Slido, ChatGPT, Deepseek ашиглах, дадлагыг 3 тивд 2025.02.09-нд зохион байгуулж 27 багш, "Эх хэлний хичээлд ашиглах шинэлэг интерактив сургалтын аргачлал" сэдэвт FIGMA.COM, MIRO.COM, GAMMA.COM, PLICKERS.COM сайтууд болон miro, gamma.app | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрхэн ашиглах сургалтыг 2025.02.16-нд зохион байгуулж 26 багш, дадлагыг 3 тивд 2025.02.23-нд зохион байгуулж 23 багш, "Эх хэлний сургалтад AI зураг болон бусад шинэлэг хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглах вэ?" сургалтыг 2025.03.16-нд зохион байгуулж 30 багш, удирдлага, "Эх хэлний сургалтад AI зураг болон бусад шинэлэг хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглах вэ?" сэдэвт klingai, Faceswapperai, hedra-aap зураг бүтээж, хөдөлгөөн, дуу яриа оруулж турших дадлагыг 3 тивд 2025.03.23-нд зохион байгуулж 20 багш, "Эх хэлний сургалтад хэрэглэх зураг, бичлэгийг боловсруулахдаа хэрхэн хиймэл оюун ухааныг ашиглах вэ?" сэдэвт сургалтыг 2025.04.13-нд зохион байгуулж 18 багш, Дадлага сургалтыг 3 тивд 2025.04.20-нд зохион байгуулж 16 багш, "Монгол бичиг ба технологи хэрэглээ" сэдэвт сургалтыг 2025.04.27-нд зохион байгуулж 30 багш, удирдлага тус тус хамруулсан.<br>Хавсралт: 23 файл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Монгол хэл, бичгээр дагнасан үзэсгэлэн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | Арга хэмжээний тоо, Гүйцэтгэлийн хувь | - | 3 (арга хэмжээ), 100 (хувь) | Гадаад улсад амьдарч байгаа иргэд, хүүхэд багачуудад Монгол эх хэл, бичиг үсэг сурах, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын үнэт зүйлийг олон улсад сурталчлахад чиглэсэн “Монгол хэл, бичиг” үзэсгэлэнг Тайвань, Япон, БНСУ-д 2025.02.21-03.23-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Үзэсгэлэнд нийт 86 оролцогчийн 229 бүтээл нийтэд хүртээл болсон.<br>Үүнд:<br>1. Япон улсад "Монгол хэл, бичиг" үзэсгэлэнг 2025.02.21-02.23-ны өдрүүдэд Япон улсын Токио хот дахь Монгол Улсын Элчин сайдын яамны хүндэтгэлийн танхим болон Миний Монгол сургуулийн Нихонбаши салбарт тус тус зохион байгуулсан. Үзэсгэлэнд Япон улсад зохион байгуулагдсан “Монгол хэл, бичиг” уралдааны оролцогчид, Япон дахь Монгол бичгийн “Нахиа” дугуйлангийн сурагчид, “Миний Монгол” сургууль, “Монголын хүүхдийн ордон”-ны сурагчдын эцэг, эхчүүдийн бичвэр, Монгол улсаас | 1-р сар, 2-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Бичиг соёл төв”, ЕБС-уудын Монгол хэл, бичгийн багш, сурагчид, “Монголын сайхан бичигтэн” уран бичлэгийн олон улсын уралдаанд оролцогчдын зэрэг нийт 65 бүтээл тавигдаж үзэгчдийн хүртээл болсон. Үзэсгэлэнг 200 гаруй хүн үзэж сонирхсон байна.<br>2. Тайвань дахь “Монгол хэл, бичиг” үзэсгэлэнг 2025.02.22-03.23-ны өдрүүдэд Тайбэй, Илан хотуудад зохион байгуулсан. Үзэсгэлэнд “Бичиг Соёл” төвийн, уран бүтээлч, зураач, судлаачийн 12, Монгол улсаас оролцож буй ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын, сонирхогчийн, Тайвань дахь “Монгол хэл, бичиг” уралдаанд ирүүлсэн зэрэг нийт 74 бүтээл тавигдан олон нийтэд толилуулсан. Үзэсгэлэнг Монгол, Тайвань болон бусад улсын нийт 331 иргэд үзэж сонирхсон байна.<br>3. “Монгол хэл, бичиг” үзэсгэлэнг Сөүл хотын Каннам дүүргийн Ёгсам Соёлын төвийн үзэсгэлэнгийн танхимд 2025.02.26-ны өдрөөс | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025.03.02-ны өдрийг хүртэл 5 өдөр зохион байгуулав. Үзэсгэлэнд Монгол улсаас оролцогч ерөнхий боловсролын сургуулийн багш нар, "Бичиг, соёл төв"-ийн, Монголын хүүхдийн ордны багш, уран бүтээлч, чөлөөт уран бүтээлчдийн нийт 78 бүтээл дэлгэгдэж олны хүртээл болсон. Үзэсгэлэнг нийт монгол, солонгос, орос 200 хүн үзэж сонирхсон байна. Хавсралт: 19 файл | | |
| 5 | Монгол хэл, бичиг заах арга зүйн гарын авлага боловсруулах | Гарын авлагын тоо, Гүйцэтгэлийн хувь | - | 50 (хувь) | Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын үнэт зүйлийг таниулахад чиглэсэн гадаад улс дахь Монгол хэл, соёлын төвийн багш нарт Монгол хэл, бичиг заах 2 шатны гарын авлага боловсруулахад дэмжлэг үзүүлж гарын авлага боловсруулах багт Насан туршийн боловсролын хэлтэстэй хамтран арга зүй, удирдлагаар хангаж, зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллаж байна. - БСҮХ-ээс зохион байгуулж буй "Гадаад улсад үйл | 1-р сар, 10-р сар, 11-р сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагуудад монгол хэлний сургалтын хэрэглэгдэхүүнийг турших" судалгааны арга зүйг танилцуулах, мэдээлэл цуглуулах хэрэгслүүдийг өгөх танилцуулга, чиглүүлэх уулзалтад оролцсон. Уулзалтад гадаад улс дахь Монгол хэл соёлын найман улс оронд үйл ажиллагаа явуулж буй 11 хэл соёлын төвийн багш, удирдлага нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй цахим уулзалт зохион байгуулагдсан. /БСҮХ-4, ГХЯ-1, БЕГ-1/.<br>- Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс боловсруулсан Баян-Өлгий аймгийн хос хэлтэй (казах) сурагчдад зориулан боловсруулсан Монгол хэлний гарын авлага, дасгал ажлын дэвтэр (II анги-Цагаан толгой), сонсох хэрэглэгдэхүүнийг турших судалгааны монгол хэлний сургалтын хэрэглэгдэхүүний туршилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх зорилготой "Эцэг, эхийн асуулга", "Багшийн асуулга"-д санал өгч ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 3 файл | | |
| 6 | Боловсролын сайдын 2024 оны “Сургалтын төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэхтэй холбогдох зарим арга хэмжээ авах тухай” А/164 дүгээр тушаалын хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангаж ажиллах | -Хамрагдсан суралцагчийн тоо -Гүйцэтгэлийн хувь | БСШУСС-ын А/626 тушаалын хэрэгжилтийн судалгаа | 280 (суралцагч), 70 (хувь) | Монгол Улс болон гадаад улс дахь буддын шашны дацан, хийдэд суралцаж буй суралцагч, ерөнхий боловсролын сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудад ерөнхий боловсролыг эзэмшүүлэх сургалтыг нийслэлийн ерөнхий боловсролын 112 дугаар сургуулийг түшиглэн зохион байгуулах, холбогдох сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх зорилгоор Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Сургалтын төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэхтэй холбогдох зарим арга хэмжээ авах тухай” А/164 дүгээр тушаал батлагдсан. Тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны А/361, А/367 дугаар тушаалыг баталж, БЕГ, БСҮХ, БҮТ, НБГ, БМТТ, Medle цахим сургууль, ЕБ-ын 112-р сургуулийн төлөөлөл бүхий нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан, нэгдсэн төлөвлөгөө гаргаж | 1-р сар, 2-р сар, 6-р сар, 8-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан.<br>*<u>Ажлын үр дүнгээс</u>*: НБГ-аас ЕБ-ын 112-р сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нөхцөл шаардлагуудыг шинэчлэн баталгаажуулах, Боловсролын салбарын мэдээллийн системд нийт 506 суралцагчийг бүртгэж, баталгаажуулах, Medle цахим сургалтын платформ дээр цонх үүсгэж хуваарилалт хийх, Сургалтын төлөвлөгөөний дагуу бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох танхимын болон цахим сургалтын хөтөлбөрийг БСҮХ-ээс боловсруулах, эцэслэх, Боловсруулсан 15 судлагдахууны хөтөлбөрт үндэслэн цагийн төлөвлөлт хийх, Танхим, цахим, нэмэлтээр судлах сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сурах бичиг, дасгал ажлын дэвтэр, багшийн ном, цахим сургалтын сан, гарын авлага, шаардлагатай хэрэглэгдэхүүний тохируулгыг БСҮХ-ээс хийх ажлуудыг зохион байгуулж ажилласан. Цахим хичээлийн нээлтийг 2025 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 02-р сарын 27-ны өдөр хийж Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд, НЕБ-ын 112-р сургуулийн төлөөлөл болон алслагдсан хөдөө, орон нутгийн нийт 200 орчим суралцагч оролцсон. Сурагчдын 600 ширхэг хувийн хэргийн захиалга хийгдсэн. БЯ, НЕБ-ын 112-р сургуулийн төлөөлөл Энэтхэг улсад ажиллаж 183 хүүхэд залуусыг хамруулсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 7 | Боловсролын ерөнхий газар, БНСУ-ын “Дэлхийн иргэний боловсрол судалгааны хүрээлэн”-тэй хамтран Монгол-Солонгос багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, хамтын хичээлээр дамжуулан багшийг хөгжүүлэх, туршлага солилцох багш, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт | Хамрагдсан багшийн тоо, Гүйцэтгэлийн хувь | 25 | 50 (хувь) | Боловсролын ерөнхий газар болон Бүгд Найрамдах Солонгос Улс дахь "Дэлхийн иргэний боловсрол судалгааны хүрээлэн" соёл урлагийн олон талт үйл ажиллагаа, хамтын хичээлээр дамжуулан багшийг хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг өргөжүүлэх зорилгоор хамтран ажиллахаар 2024 онд санамж бичиг байгуулсан. Энэ санамж бичгийн хүрээнд 2025 онд Монгол улсад зохион байгуулагдах сургалт, үйл | 1-р сар, 6-р сар, 8-р сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагааг Дундговь болон Төв аймгаас албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг "Дэлхийн иргэний боловсрол судалгааны хүрээлэн"-д Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 1/380 албан бичгээр уламжилсан. Уламжилсан хүсэлтийн дагуу Дундговь аймагт 2025 оны 07-р сарын 28-ны өдрөөс 07-р сарын 30-ны өдрүүдэд, Төв аймагт 2025 оны 08-р сарын 04-ний өдрөөс 08-р сарын 06-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахаар сургалтын агуулга, хөтөлбөр, сургалтын танхим, сургалтад хамрагдах багш нарын мэдээлэл болон бусад бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Хавсралт: 7 файл | | |
| 3.1. Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль, тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх; | | | | | | | |
| 8 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг хянан шийдвэрлэх | Өргөдөл, гомдол, ирсэн, явсан бичгийн тоо, шийдвэрлэлтийн хувь | Ирсэн бичиг 9, Явсан бичиг 15 | 100 | Ажлын чиг үүргийн дагуу Гадаад харилцааны яам, Соёлын яам, Боловсролын яам болон харьяа байгууллагууд, Боловсролын ерөнхий газрын газар, хэлтсүүд, нийслэл, орон нутгийн боловсролын газар, Хилийн чанад дахь Монголчуудын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөлийн Боловсролын хороо бусад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг мэдээ мэдээллээр хангаж, удирдах дээд байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, нэгжийн дотоод үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Үүнд:<br>- Боловсролын яамны холбогдох газар хэлтсүүдэд шаардлагатай тоон мэдээлэл, тайлангуудыг цаг тухай бүрд нь хурдан, шуурхай гаргаж, бусад шаардлагатай үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.<br>- Албан хаагчийн болон хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг боловсруулах, хэрэгжилт, биелэлтийг цаг тухай бүр гаргах, тайлбар мэдээллийг өгч ажиллаж байна.<br>- Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- 5 албан бичиг ирснийг шийдвэрлэж хариуг албан бичиг болон бусад хэлбэрээр асуудлыг шийдвэрлэсэн.<br>- Чиг үүргийн хүрээнд | сар, 12-р сар | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 11 албан бичиг боловсруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад илгээсэн. Боловсролын ерөнхий газрын даргын үүрэг болгосны дагуу хариуцсан чиг үүргийн хүрээнд дараах тушаалуудын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна. Үүнд:<br>1. Боловсролын сайдын 2025 оны “Чиглэл батлах тухай” А/229 дугаар тушаал,<br>2. Боловсролын сайдын 2024 оны “Сургалтын төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэхтэй холбогдох зарим арга хэмжээ авах тухай” А/164 дүгээр тушаал,<br>3. Гадаад харилцааны сайд, Соёлын сайд, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын хамтарсан 2024 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/23, А/55, А/156, А/151 дугаар тушаал.<br><u>Мэдээ, мэдээлэл:</u><br>1. Бодлогын хэрэгжилтийн 2, тушаалын хэрэгжилтийн 1, цаг үеийн сургалт, үйл ажиллагааны 13 мэдээ, мэдээллийг байгууллагын цахим | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуудаст нийтлүүлсэн. | | |
| 9 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Архивын нэгжийн тоо, гүйцэтгэлийн хувь | 2 баримт | 2 (боть), 100 (хувь) | - Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэн бичиж, хэвлэж, байна. 2025 оны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн ажлын холбогдох материалыг жилийн эцэст архивлахад бэлтгэн хадгалж байна.<br>- 2024 оны сургалт, үйл ажиллагааны баримт бичгийг архивлаж, 2 хавтас үдсэн баримт архивд хүлээлгэн өгсөн. (гадаад улс-1, үндэсний цөөнх-1)<br>- Хос хэлний боловсрол, сургалтын талаар баримтлах чиглэл<br>- Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам<br>- Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам<br>- Үзэл баримтлал батлах тухай (Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал)<br>- Гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй боловсролын сургалтын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Ажлын чиг үүргийн дагуу уулзалт, зөвлөгөөн, форум, сургалтад хамрагдах; | Гүйцэтгэлийн хувь | 5 | 100 | - Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан "Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт цахим сургалтад 100%-ийн гүйцэтгэлтэй хамрагдсан.<br>- Хос хэлний талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой уулзалтад хамрагдсан. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 100% |
| 2 | Албан тушаалын онцлогоос хамаарсан мэдээллийн технологийн болон бусад шаардлагатай ур чадварыг сургалтын байгууллагаар болон бие даан тасралтгүй | Гүйцэтгэлийн хувь | 5 | 100 | 1. Боловсролын салбарын өгөгдлийг үүсгэх, нэгтгэх, шинжлэх, өгөгдлийн шинжилгээг хэрэглэх, хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдсан. (БЯ-2025.04.16-ны | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 6-р сар, 8-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эзэмших. | | | | өдөр 09:00-12:00 цагт)<br>2. "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл" сургалтад хамрагдав. 2025.05.08<br>3. Мэдээлэл хүргэх цаг- “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” хамрагдав. 2025.05.07<br>4. Хиймэл оюун ухаан (AI) хэрхэн ашиглах талаар бие даан суралцаж байна. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Үндэсний цөөнх, хилийн чанад дахь монгол хүүхдийн хэл, соёлын асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Лханаг Батсүрэн
/................................................/ Огноо: .........................